



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/12

Бор-өндөр сум

Хөдөлмөрийн дотоод журмыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалт, Байгууллагын албан хаагчдын 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэгдсэн эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг нэгдсэн эмнэлгийн албан хаагч нарт танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дарга /Т.Баярчимэг/-т даалгасугай.

ДАРГА  А.БАТБААТАР

